ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

  2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

  2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

  2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

  2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

  2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........ 8

  3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

  3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

  3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан........ 13

  4.1 Ерөнхий зүйл ........ 13

  4.2 Материаллаг байдал ........ 14

  4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........ 14

  4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14

  4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

  4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16

5. Аудитын илрүүлэлт ........ 16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 60

танай -ны № -т

ТЭС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.ЦЭЭПИЛМАА-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тэс сумын Эрүүл мэндийн төвд 2024 онд Эрүүл мэндийн яамнаас 160,000,0 мянган төгрөгийн түргэн тусламжийн автомашин, 34,774,5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, өөрийн хөрөнгөөр 35,075,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авчээ.

Аудитын гол асуудал

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж, эвдэрч муудсан бусад үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 6,630.0 мянган төгрөгийн модон жорлон, 450.0 мянган төгрөгийн программ хангамжийг акталж дансны бүртгэлээс хасаагүй, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч 1,471.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар 43,000.0 мянган төгрөгийн фургон автомашиныг 17,916.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй сумын Ерөнхий боловсролын

балансаас балансt шилжүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *(/төгрөгөөр/)*

| Данс | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **7,271,295,677.99** | **358,673,886.13** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **150,380,379.87** | **72,740,999.57** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 150,380,379.87 | 72,740,999.57 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 150,380,379.87 | 72,740,999.57 |
| **33** | **АВЛАГА** | **13,337,782.00** | **195,700,535.82** |
| **33100** | **Ажиллагчидтай холбогдсон авлага** | **228,145.00** | |
| 33102 | НДШ-ийн авлага | 228,145.00 | |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | 13,108,742.00 | 195,699,640.82 |
| 33500 | Бусад авлага | 895.00 | 895.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 895.00 | 895.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 107,577,516.12 | 90,232,350.74 |
| **351** | **Түүхий эд материал** | 10,814,561.98 | 15,721,162.30 |
| 35130 | Эм боох материал | 10,814,561.98 | 15,721,162.30 |
| **354** | **Хангамжийн материал** | 34,342,969.60 | 28,146,130.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,032,300.00 | 880,950.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,839,601.00 | 33,288,301.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 575,000.00 | 275,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 360,455.00 | 40,189.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,759,024.00 | 4,455,080.00 |
| **35470** | **Бусад хангамжийн материал** | **56,996,574.14** | **35,171,668.44** |
| 35600 | Мал амьтад | 3,200,000.00 | 400,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **436,772,568.24** | **576,329,088.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 436,772,568.24 | 576,329,088.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 420,740,568.24 | 558,939,088.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 337,067,300.00 | 337,067,300.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (43,331,426.40) | (56,330,854.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 52,490,000.00 | 169,490,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (22,339,999.81) | (28,037,222.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 176,966,213.63 | 246,815,686.95 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (91,583,804.63) | (118,739,635.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,796,621.00 | 20,796,621.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,496,335.55) | (12,294,807.55) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,630.00 | 6,630.00 |
| **39215** | **Хуримтлагдсан элэгдэл-Бусад үндсэн хөрөнгө** | (6,630.00) | (6,630.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,032,000.00 | 16,032,000.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (450,000.00) | (450,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,032,000.00 | 17,390,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **708,068,246.23** | **935,002,974.35** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **708,068,246.23** | **935,002,974.35** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **708,068,246.23** | **935,002,974.35** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 129,305,500.35 | 129,305,500.35 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 129,305,500.35 | 129,305,500.35 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 175,199,640.88 | 402,134,369.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 64,249,368.71 | 175,199,640.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 110,950,272.17 | 226,934,728.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 403,563,105.00 | 403,563,105.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **708,068,246.23** | **935,002,974.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **776,961,243.43** | **1,228,928,365.77** |
| **11** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **43,656,412.81** | **212,829,631.09** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 43,656,412.81 | 212,829,631.09 |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | 1,090,000.00 | 3,500,000.00 |
| **1200042** | **туслах үйл ажиллагааны орлого** | | 3,500,000.00 |
| **1200045** | **Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого** | 1,090,000.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 30,834,139.00 | 196,132,473.32 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 11,732,273.81 | 13,197,157.77 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **733,304,830.62** | **1,016,098,734.68** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс** | 29,293,300.00 | 33,872,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орог нутгийн төсөвт байгууллага/ | 29,293,300.00 | 33,872,800.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 696,651,638.62 | 954,725,934.68 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 696,651,638.62 | 954,725,934.80 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,359,892.00 | 27,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | 27,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3359892,00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **666,010,971.26** | **976,910,304.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **666,010,971.26** | **976,910,304.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 664,933,639.54 | 972,890,936.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 404,458,329.75 | 601,936,554.88 |
| 210101 | Үндсэн цалин | 253,783,211.75 | 340,098,905.08 |
| 210102 | Нэмэгдэл | 108,945,309.00 | 193,869,899.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,271,000.00 | 11,621,000.00 |
| 210104 | Урамшуулал | 37,458,809.00 | 56,346,750.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,689,589.00 | 73,907,065.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,480,708.25 | 51,799,720.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,770,094.10 | 6,083,268.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,235,387.03 | 3,005,334.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 745,763.25 | 2,600,931.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,457,636.37 | 10,417,810.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25264718,28 | 30733531,82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2105684,28 | 2706928,82 |
| 210302 | Түлш, халаалт | 23105460,00 | 27876603,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 53574,00 | 150000,00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,145,617.60 | 87,445,029.47 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,594,100.00 | 4,308,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,091,910.00 | 31,097,266.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,188,500.00 | 1,980,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 26,341,107.60 | 47,258,813.47 |
| 210408 | Бараа материал актлалсны зардал | 5,930,000.00 | 2,800,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 62,150,774.76 | 76,738,992.68 |
| 210501 | Эм ,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 53,244,089.76 | 66,153,298.68 |
| 210502 | Хоол ,хүнс | 8,906,685.00 | 10,585,694.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,487,750.00 | 7,148,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,487,750.00 | 7,148,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,008,300.00 | 17,119,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,008,300.00 | 17,119,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 825,446.00 | 2,586,992.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,777,300.00 |
| 210802 | Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,000.00 | 139,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 189,000.00 | 130,692.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 446.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,903,114.15 | 75,274,769.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,384,800.00 | 8,707,150.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,518,314.15 | 66,567,619.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,077,331.72 | 4,019,368.18 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 3,880,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 3,880,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,077,331.72 | 139,368.18 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,077,331.72 | 0.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 139,368.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **110,950,272.17** | **252,018,061.52** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 25,083,333.40 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 25,083,333.40 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | 110,950,272.17 | 226,934,728.12 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *(/төгрөгөөр/)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **720,326,299.62** | **837,007,835.86** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **3,500,000.00** |
| **1200** | **Нийтлэг татварын бус орлого** | | **3,500,000.00** |
| **1200042** | **Туслах үйл ажиллагааны орлого** | | **3,500,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **720,326,299.62** | **833,507,835.86** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,293,300.00 | 33,872,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,293,300.00 | 33,872,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,359,892.00 | 27,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | 27,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,359,892.00 | - |
| 1340 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 683,673,107.62 | 772,135,035.86 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 683,673,107.62 | 772,135,035.86 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **612,945,175.75** | **879,572,216.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **612,945,175.75** | **879,572,216.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **611,867,844.03** | **875,552,847.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 403,051,555.75 | 601640247,88 |
| 210101 | Үндсэн цалин | 223,140,019.75 | 287856189,08 |
| 210102 | Нэмэгдэл | 129,958,561.00 | 245,816,308.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,271,000.00 | 11,621,000.00 |
| 210104 | Урамшуулал | 45,681,975.00 | 56,346,750.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,109,068.50 | 73,975,227.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,390,044.73 | 51,887,450.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4151239,48 | 6,081,535.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3268192,33 | 3,004,467.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 752836,83 | 2,600,353.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7528371,63 | 10,401,419.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,264,718.28 | 30,733,531.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,105,684.28 | 2,706,928.82 |
| 210302 | Түлш, халаалт | 23,105,400.00 | 27,876,603.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 53,574.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,638,092.00 | 49,490,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,143,800.00 | 3,157,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,154,892.00 | 30,777,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,188,500.00 | 1,980,000.00 |
| 210405 | хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал | 1,009,500.00 | 3,508,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,141,400.00 | 10,067,050.00 |
| 2105 | Нормативт зардал | 62,612,496.00 | 81,341,649.00 |
| 210501 | Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл | 52,342,896.00 | 71,059,899.00 |
| 210502 | хоол хүнс | 9,269,600.00 | 10,281,750.00 |
| 210503 | нормын хувцас зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 0,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,991,751.00 | 9,958,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,251,000.00 | 119,900.00 |
| 210603 | хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,953,001.00 | 2,790,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,787,750.00 | 7,048,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,008,300.00 | 17,119,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,008,300.00 | 1,719,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 825,446.00 | 2,586,992.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0,00 | 1,777,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,000.00 | 139,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 0,00 |
| 210807 | газрын төлбөр | 189,000.00 | 130,692.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 446.00 | 0,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,384,800.00 | 8,707,150.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,384,800.00 | 8,707,150.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,077,331.72** | **4,019,368.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 3,880,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 3,880,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,077,331.72 | 139,368.18 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,077,331.72 | 0,00 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0,00 | 139,368.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **107,381,123.87** | **(42,564,380.30)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **20,155,500.00** | **35,075,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,155,500.00** | **35,075,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,155,500.00 | 35,075,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,155,500.00 | 35,075,000.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 872,256,23.87 | -77639380.30 |
| **14** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 63,154,756.00 | 150,380,379.87 |
| **15** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 150,380,379.87 | 72,740,999.57 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 129,305,500.36 | 403,563,105.00 | 64,249,368.71 | 597,117,974.07 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 129,305,500.36 | 403,563,105.00 | 64,249,368.71 | 597,117,974.06 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 110,950,272.17 | 110,950,272.17 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 129,305,500.36 | 403,563,105.00 | 175,199,640.88 | 708,068,246.24 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 129,305,500.36 | 403,563,105.00 | 175,199,640.88 | 708,056,246.23 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 129,305,500.36 | 403,563,105.00 | 175,199,640.88 | 708,056,246.23 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 226,934,728.12 | 226,934,728.12 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 129,305,500.35 | 403,563,105.00 | 402,134,369.00 | 935,002,974.35 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 685,471,700 | 603,807,375.75 | 1,032,683,800 | 880,774,416.16 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 685,471,700 | 603,807,375.75 | 1,032,683,800 | 880,774,416.16 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 685,471,700 | 603,807,375.75 | 1,032,683,800 | 876,894,416.16 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 415,217,300 | 403,051,555.75 | 633,108,000 | 601,640,247.88 |
| 210101 | Үндсэн цалин | 211,693,300 | 223,140,019.75 | 314,592,000 | 287,856,189.08 |
| 210102 | Нэмэгдэл | 152716000..0 | 129,958,561.00 | 251,908,000 | 245,816,308.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000 | 4,271,000.00 | 5,808,000 | 11,621,000.00 |
| 210104 | Урамшуулал | 45,000,000 | 45,681,975.00 | 60,800,000 | 56,346,750.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,902,100 | 51,090,685.00 | 79,138,500 | 73,975,227.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,293,500 | 35,390,044.73 | 53,814,200 | 51,887,450.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,152,200 | 54,151,239.48 | 6,331,100 | 6,081,535.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,321,700 | 3,268,192.33 | 3,165,500 | 3,004,467.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 830,400 | 752,836.83 | 3,165,500 | 2,600,353.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,304,300 | 7,528,371.63 | 12,662,200 | 10,401,419.96 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,780,000 | 37,294,592.00 | 71,878,800 | 49,490,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,600,000 | 3,143,800.00 | 63,877,600 | 3,157,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,300,000 | 21,154,892.00 | 49,900,000 | 30,777,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,680,000 | 2,188,500.00 | 3,360,600 | 1,980,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал | 3,400,000 | 3,009,500.00 | 4,112,400 | 3,508,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,800,000 | 7,797,900.00 | 10,328,200 | 10,067,050.00 |
| 2105 | Нормативт зардал | 76,198,000 | 66,612,496.00 | 107,880,000 | 81,341,649.00 |
| 210501 | Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл | 64,370,000 | 56,342,896.00 | 93229700,00 | 71,059,899.00 |
| 210502 | хоол хүнс | 10,228,000 | 9,269,600.00 | 12025300,00 | 10,281,750.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 1,600,000 | 1,000,000.00 | 2,625,000 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 42,800,000.00 | 31,089,501.00 | 76,625,000 | 45,033,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 35,000,000 | 24,300,000.00 | 62,000,000 | 35,194,900.00 |
| 210603 | хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 3,000,000 | 2,953,001.00 | 3,000,000 | 2,790,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,800,000 | 3,836,500.00 | 11,625,000 | 7,048,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,500,000 | 8,008,300.00 | 17,230,000 | 17,119,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,500,000 | 8,008,300.00 | 17,230,000 | 17,119,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2524000,00 | 825446,,00 | 9,983,500 | 2,586,992.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0,00 | - | 7,846,500 | 1,777,300.00 |
| 210802 | Аудит баталгаажуулат зэрэглэл тогтоох | 540,000 | 540,000.00 | 540,000 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000 | - | 60,000 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,000 | 63,000.00 | 148,000 | 139,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000 | 33,000.00 | 99,000 | - |
| 210807 | Газрын төлбөр | 189,000 | 189,000.00 | 189,000 | 130,692.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 48,000 | 446,00 | 48000,00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх | 1,440,000 | - | 1,053,000 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,550,300 | 5,834,800.00 | 36,840,000 | 8,707,150.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,550,300 | 5,834,800.00 | 36,840,000 | 8,707,150.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,518,000 | 16,518,000.00 | 158,365,000 | 3,880,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,518,000 | 16,518,000.00 | 158,365,000 | 3,880,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | - | 5,400,000 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,518,000 | 16,518,000.00 | 51,725,200 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | 99,639,800 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | 1,600,000 | 3,880,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 685,471,700 | 860,380,737.57 | 1,032,683,800 | 803,135,035.86 |
| **12** | **Нийтлэг татварын бус орлого** | | | | 3,500,000.00 |
| 120010 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | | | | 3,500,000.00 |
| 122001 | Хандив тусламж/дотоод/ | | | | 27,500,000.00 |
| 122004 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 685,471,700 | 603,807,375.70 | 1,032,683,800 | 772,135,035.86 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **22.00** | **22.00** | **22** | **22.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 1 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 22.00 | 22 | 22.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 16.00 | 17 | 17.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | 4 | 4.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **33,733,431.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **33,733,431.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 33,733,431.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 2,229,600.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | | 2,706,928.82 |
| 210302 | Түлш халаалт | | 27,876,603.00 |
| 210303 | цэвэр бохир ус | | 150,000.00 |
| **2106** | **Эд хогшил урсгал засварын зардал** | | 2,999,900.00 |
| 210604 | Урсгал засвар | | 2,999,900.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 33,733,431.82 |
| **122005** | **орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 33,733,431.82 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Эрүүл мэндийн төв:** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр тэргүүлэгч эрүүл мэндийн төв болох зорилготой.

**Эрхэм зорилго**: Иргэд хамт олны идэвх оролцоотойгоор эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэн чадварлаг хамт олныг бүрдүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг жигд сайжруулахад оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн салбарын *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Эрүүл мэндийн тухай хууль
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус газар нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл болон мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 226,937.7 мянган төгрөгөөр буюу 31.1 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 13,337.7 | 195,700.5 | |
| Бараа материал | 107,577,5 | 90,232.3 | -17,345.2 |
| Үндсэн хөрөнгө | 603,980,7 | 792,188.2 | 188,207.5 |
| **Нийт хөрөнгө** | **708,068,2** | **935,002,9** | **170,862.3** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 129,305,5 | 129,305.5 | |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **708,068.2** | **935,005.9** | **226,937.7** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

**Үндсэн хөрөнгө:** Байгууллагын төсвөөс 3,300.0 мянган төгрөгийн мотор худалдан авч, ЭМГ-ын даргын А/09 дүгээр тушаалаар 1,950.0 мянган төгрөгийн термостат, 3,780.0 мянган төгрөгийн суурин компьютер, Эрүүл мэндийн сайдын 2024.12.12-ны А/603 дугаар тушаалаар 160,000.0 мянган төгрөгийн Ландкруйзер автомашин, 15,364.2 мянган төгрөгийн мобайль багц тоног төхөөрөмж, ЭМГ-аас багийн эмч нарт 11,241.1 мянган төгрөгийн 4 ширхэг зөөврийн компьютер, Глобал сангаас үнэ төлбөргүйгээр 5,680.4 мянган төгрөгийн автоклов, ЭМЯ-наас 27,500.0 мянган төгрөгийн зөөврийн эхо аппарат зэрэг хөрөнгө ирснийг орлого авч, санхүүгийн тайланд тусгасан нь хөрөнгө өсөхөд нөлөөлсөн байна.

Төрийн өмчийн бодлого,зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансат шилжүүлэх тухай" 262 дугаар тогтоолоор 43,000.0 мянган төгрөгийн УАЗ фургон маркийн авто машиныг Тэс сумын ЕБС-д балансаас балансат шилжүүлсэн байна.

**Бараа материал:** Эхний үлдэгдэл 107,577.5 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 138,229.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 13,197.1 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 168,772.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 90,232.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 129,305.5 мянган төгрөг нь тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс 1,032,683.8 мянган тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 151,909.4 мянган төгрөг буюу хэмнэгдсэн үзүүлэлттэй гарч байгаа боловч авлага үүссэний улмаас 85.2 хувьтай байна. Энэ нь цалин 31,467.7 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 34,591.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 28,132.8 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **ЭМД сангаас санхүүжих** | | | | | |
| 80302 | Нэг иргэн нормативаар тооцсон | 724,474.0 | 678,101.9 | | 93.5% |
| 81603 | Үндсэн тусламж үйлчилгээ зардал | 214055,0 | 147,482.4 | | 68.8% |
| 83603 | Нэмэлт шатны санхүүжилт | 95,154.8 | 55,190.0 | | 58.0% |
| **НИЙТ** | | **1,032,683.8** | **880,774.4** | **151,909.4** | **85.2%** |

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд худалдан авалт | Хэт авиан оношилгооны аппарат | 27,500.0 | 27,500.0 |
| 2 | Шууд худалдан авалт | Халдваргүйтгэгч ба цэвэрлэгээний кабинет | 495.0 | 495.0 |
| 3 | Шууд худалдан авалт | Компьютер суурин | 3,780.0 | 3,780.0 |
| 4 | Шууд худалдан авалт | ТР мотор | 3,300.0 | 3,300.0 |
| | **Дүн** | | **35,075.0** | **35,075.0** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн  2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,228,928.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 24,578.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19,662.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,228,928.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 24,578.5

мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19,662.8 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудит**

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 1,977.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,996.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн актыг барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,977.2 | 1 | 1,977.2 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 5,996.0 | 1 | 5,996.0 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **7,973.2** | **2** | **7,973.2** | **100%** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,551.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 заалт зөвлөмж өгсөн.

**Залруулсан алдаа: байхгүй**

**5.1 Төлбөрийн акт тогтоогдоогүй**

**5.2 Албан шаардлага өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт*:** Эрүүл мэндийн төвийн даргад 1,471.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, байгууллагын даргад балансын урамшуулал дахин олгохгүй байх;

***Илрүүлэлт*:** Бусад үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 7,080.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 7,080.0 мянган төгрөгийн холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 8,551.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч балансын 1471.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон | 1 | 1,471,000 | | | | | 1 | 1,471,000 | | | | |
| Бусад үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 7,080.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | 7,080,000 | | | | | 1 | 7,080,000 | | | | |
| **Дүн** | **2** | **8,551,000** | | | | | **2** | **8,551,000** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-20

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-20